



Есүс Христ нэгэн эрийг эдгээсэн нь

Нэг өдөр Есүс Христ төрөлхийн сохор эрийг харжээ. Зарим хүн Бурхан түүнийг шийтгэж сохор болгосон гэж бодож байв. “Энэ хүн өөрөө нүгэл үйлдсэн юм уу? Эсвэл эцэг эх нь үү? гэж тэд асууцгаав.

Тэр сохор байгаа нь шийтгэл биш. “Энэ ч, эцэг эх нь ч нүгэл үйлдсэнээс болоогүй” гэж Есүс хэлэв.

Есүс түүний нүдэнд шавар тавиад цөөрөмд очиж угаа гэв. Өнөөх хүн Есүсийн хэлснийг хийхэд тэр эдгэрчээ! Тэр хараатай болов.

Заримдаа хэцүү бэрх зүйл бидэнд тохиолддог. Есүс Христ, Тэнгэрлэг Эцэг хоёр биднийг суралцаж, өсөж хөгжин, амар амгалан байхад тусалж чадна. Тэд биднийг хайрладаг бөгөөд адислахыг хүсдэг! ●

Та нар энэ түүхийг Иохан 9:1-11-ээс уншиж болно.

Энэ цаасыг салгаж аваад, дундуур нь нугал. Түүхийг ярьж байхдаа, энэ зургийг дээш барь.

